

БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА *Н.Пүрэвсүрэн* Н.ПҮРЭВСҮРЭН
2025 оны 02 дугаар сарын 03.

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 03

Дугаар 02

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 14:00 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн гүйцэтгэх захирлын өрөөнд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Паркийн дэд бүтцийн ажил болох 2 сувагчлал бүхий 1.4 км урттай үерийн байгууламжийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.02.03.

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг гүйцэтгэх захирлын өрөөнд 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 14:00 цагт эхэлж 14:30 цагт дуусгав. Хуралд өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга Н.Пүрэвсүрэн гишүүд Э.Энгүүн, О.Чулуун-Эрдэнэ, Г.Ганцэцэг нар болон нярав Э.Ундармаа нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Паркийн дэд бүтцийн ажил болох 2 сувагчлал бүхий 1.4 км урттай үерийн байгууламжийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх тухай

СОНССОН НЬ: Өмчийн харилцааны газраас ирүүлсэн 2025 оны 01 сарын 24-ны өдрийн 2/119 тоот албан бичигт “Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын 1710 у/м хүчин чадал бүхий Үерийн далангийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн МС-124/2020 дугаартай Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.4-т заасны дагуу шинээр бий болсон нийт 1,014,348,731.00 (нэг тэрбум арван дөрвөн сая гурван зуун дөчин найман мянга долоон зуун гучин нэг) төгрөгийн өртөг бүхий эд хөрөнгийг холбогдох дансанд бүртгэн авч, хөрөнгө бүртгэлд авсан тухай тушаалын хуулбарыг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн дотор ирүүлэхийг хүсье” гэжээ.

Н.Пүрэвсүрэн: Өмчийн харилцааны газраас ирүүлсэн албан тоотын хүрээнд Гүйцэтгэх захирлын тушаал гарсан байна. Юутай ч байгууллагын дэд бүтцийн ажил болох үерийн байгууламжаа өөрийн хөрөнгөд авах сайн нөхцөл үүсчээ.

Г.Ганцэцэг: Захирлын тушаал өнөөдөр гарсан учраас бид хөрөнгөө өөрийн холбогдох дансанд бүртгэн авч Өмчийн харилцааны газар хүргүүлнэ.

О.Чулуун-Эрдэнэ: Өмч маань бидэнд шилжин ирж байгаа нь маш сайн хэрэг. Цаашид бид ашиглалт тал дээрээ илүү анхаарч байнга хянаж, тордож, эвдэрч хагарсан газар байна уу шалгаж байх хэрэгтэй.

Н.Пүрэвсүрэн: Тийм шүү. Ашиглалтын зардал бага хэмжээгээр гарах л байх. Гэхдээ бидний өмч учраас эвдэрч хагарсан тохиолдолд бид засаж сэлбэж байх нь зүйтэй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Паркийн дэд бүтцийн ажил болох 2 сувагчлал бүхий 1.4 км урттай үерийн байгууламжийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэн авч цаашид өөрийн хөрөнгөд тоолж ашиглаж байхаар шийдвэрлэв. Ашиглалтын явцад гарах урсгал зардлыг тухай бүр нь тооцон гаргаж танилцуулж байх. Бүртгэл хөтлөлтийг журмын дагуу хийхийг Нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах комиссын

Дарга

Гишүүд



Н.Пүрэвсүрэн /Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/

Э.Энгүүн /Маркетингийн мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /Гадаад харилцаа, хамтын ажиллагааны мэргэжилтэн/



Г.Ганцэцэг /Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга/
Э.Ундармаа /Нярав/

